



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (590)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны тавдугаар сарын 04 №17 (590)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

223. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай 400

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

224. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 30 400
225. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 32 400

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

226. Дашдондогийн Болдод Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай Дугаар 65 400
227. Лувсанбатын Мягмарт Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 66 401
228. Бадамдоржийн Батчулуунд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай Дугаар 67 401
229. Нинжийн Дэжимбээд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай Дугаар 68 401
230. Бадамсүрэнгийн Энхравданд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай Дугаар 69 401
231. Магаагийн Саранчулуунд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай Дугаар 70 402
232. Жамъяндоржийн Бямбаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 71 402
233. Даваажанцангийн Сарангэрэлд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 72 402
234. Самандын Жавхланд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 73 402
235. Түвшинжаргалын Баясгаланд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 74 403

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

236. Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай Дугаар 13 403
237. Дүрэм батлах тухай Дугаар 14 403

Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

238. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 03 411

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ

2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

өдрөөс нь буюу 2009 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Тэмүүжин, Дангаасүрэнгийн Энхбат нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

1. Улсын Их Хурлын гишүүн Санжаасүрэнгийн Оюуныг Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төсвийн байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил, Хишигдэмбэрэлийн

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

1. Улсын Их Хурлын гишүүн Дэлэгийн Загдзавыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төсвийн байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Дагвадоржийн Очирбатыг

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Дашдондогийн Болдод Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, сургалт эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвиж, боловсролын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дээд боловсролыг хөгжүүлэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж Улаанбаатар дээд сургуулийн дэд захирал, профессор Дашдондогийн Болдод Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Лувсанбатын Мягмарт Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээх тухай

Усны барилга байгууламжийн хайгуул судалгаа, зураг төслийн ажилд олон жил үр бүтээлтэй ажиллаж, усыг зөв зохистой ашиглах, хамгаалах болон усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн усны нөөц, ус

ашиглалтын салбарын зураг төслийн менежер Лувсанбатын Мягмарт Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Бадамдоржийн Батчулуунд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын мэдлэг чадвар, заах үр чадварыг дээшлүүлэх, чадварлаг хамт олныг бүрдүүлж, сургалтын арга барилыг боловсронгуй болгох, боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь

үнэлж Дархан-Уул аймгийн Монгол-Туркийн хамтарсан 21 дүгээр сургуулийн захирал Бадамдоржийн Батчулуунд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Нинжийн Дэжимбээд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллан, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, үндэсний спортын дээд боловсролтой боловсон хүчин, багш нарыг сургаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж "Шонхор-

Олимп" дээд сургуулийн багш Нинжийн Дэжимбээд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Бадамсүрэнгийн Энхравданд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хүүхдийн мэс заслын эмчилгээний чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, хүүхдийн бөөрний эмгэгийн үеийн мэс заслын эмчилгээнд шинэ арга ажиллагааг амжилттай нэвтрүүлж, залуу эмч нарыг сурган дадлагажуулах, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч, их эмч Бадамсүрэнгийн Энхравданд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Магаагийн Саранчулуунд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, хорт хавдрыг эмчлэх химийн эмчилгээнд шинэ арга ажиллагаа нэвтрүүлэн, хавдар судлалын албыг бэхжүүлэх, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарыг сургаж

бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хавдар судлалын үндэсний төвийн тасгийн эрхлэгч, их эмч Магаагийн Саранчулуунд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Жамъяндоржийн Бямбаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Радио, телевизийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж, төрөл бүрийн нэвтрүүлгүүдийг мэргэжлийн өндөр түвшинд хөтөлж, нэвтрүүлгийн чанарыг сайжруулах, үндэсний радио, телевизийн алтан сан хөмрөгийг баяжуулах, залуу нэвтрүүлэгч, хөтөлөгчдийг сургаж бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын үндэсний

олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлэгч Жамъяндоржийн Бямбаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Даваажанцангийн Сарангэрэлд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллагад идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, мэдээлэл технологийн орчин үеийн дэвшилтэт арга хэлбэрүүдийг Монголын хэвлэл мэдээллийн салбарт нэвтрүүлэн, телевизийн уран бүтээлийн агуулга хэлбэрийг баяжуулж, шинэлэг чанартай нэвтрүүлгүүдийг үзэгчдийн хүртээл болгон,

мэдээллийн хэрэгслийн бие даасан байдал, телевизийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж TV-5 телевизийн ерөнхий захирал Даваажанцангийн Сарангэрэлд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Самандын Жавхланд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

"Насан багын дурсамж", "Монголын үнэртэй салхи", "Хүүгийн бодол" зэрэг томоохон уран бүтээлүүдээ олон түмний хүртээл болгож, хөгжмийн өвөрмөц содон найруулга, хоолойн өргөн цар хүрээ, дуулаачийн төрөлх авъяас чадвар, шинэлэг менежментээрээ Монголын соёл урлаг, түүний

дотроос нийтийн дууны урлагийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дуучин Самандын Жавхланд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Түвшинжаргалын Баясгаланд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

"Сүүтэй зүүдэн", "Зөвхөн чамдаа", "Бүүвэйн залбирал" зэрэг өвөрмөц өнгө аястай, томоохон бүтээлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг бүтээж, олон түмний хүртээл болгон, Монголын соёл урлаг, түүний дотроос мэргэжлийн болон нийтийн дууны урлагийн хөгжилд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж дуучин Түвшинжаргалын Баясгаланд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сумын хүн ам, газар нутгийн хэмжээ, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, төрийн үйлчилгээний байгууллагуудын ажиллах хүрээг харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 10, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 12, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 13, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 15, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 18, 20001-ээс дээш хүн амтай суманд 20 байхаар тус тус тогтоосугай.

2. Сумын Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн талаар санал

боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр энэ оны 1 дүгээр сард багтаан баталж, мөрдүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 264 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21.1.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2000 оны 7

дугаар сарын 5-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Т.ГАНДИ

Засгийн газрын 2009 оны 14 дүгээр тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага /цаашид

"ажил олгогч" гэнэ/-д гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судалж тогтоох, тэдгээрийг бүртгэх, тайлагнах, мэдээлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх үйл ажиллагаанд Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

1.3. Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогч, иргэд, хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нэгэн адил мөрдөнө.

1.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхтэй холбогдон гарах бүх зардал (үйлдвэрийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэн (цаашид "осолдогч" гэнэ)-ийг эмнэлэгт хүргэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, ороох боох материал, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч, шинжээчийн үйл ажиллагаа, тээврийн зардал, ослын шалтгааныг арилгахад шаардгдах хөрөнгө гэх мэт)-ыг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн тухайн ажил олгогч бүрэн хариуцна.

1.5. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан дараахь нөхцөл байдалд гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд тооцно:

1.5.1. ажилтан ажлын үндсэн болон туслах байранд, эсхүл гэрээ хэлэлцээр, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолт, дайчилгаагаар бусад газарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа;

1.5.2. ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил үүргээ гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу яган явж байх үед;

1.5.3. ажлын байраа орхиж боломжгүй ажил үүргээ гүйцэтгэдэг ажилтан ажлын байрандаа амарч байх, ажил эхлэхийн өмнө болон ажил дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгсэлээ эмхлэн цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;

1.5.4. ажилдаа ирэх, буцах замдаа аливаа тээврийн хэрэгсэлээр буюу яган явж байхдаа (энэхүү ослыг тогтооходоо тухайн ажилтны гэр, ажлын байр хоорондын чиглэл, цаг хугацааг үндэс болгоно);

1.5.5. үндсэн ажил үүргээ гүйцэтгэх үедээ байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химийн хорт бодисын нөлөөлөл, биологийн гаралтай өвчин үүсгэгчийн гэнэтийн аюулд өртсөн;

1.5.6. тухайн байгууллагад ашиглаж байгаа түүхий эд, материал болон бусад технологийн процессод ашигладаг химийн бодис, биологийн гаралтай бохирдуулагчийн улмаас үүссэн өвчин, хордлогод өртсөн;

1.5.7. байгалийн гэнэтийн аюул, гамшиг, хөнөөх хэрэгслийн болон гоц халдварт өвчний голомт, сүйрэл, дэлбэрэлтийн үед.

1.6. Ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ зам тээврийн осолд орсон тохиолдолд ослыг замын цагдаагийн байгууллагын дүгнэлтийн дагуу

хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж баталгаажуулна.

1.7. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан дараахь нөхцөл байдалд гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд тооцохгүй:

1.7.1. ажил олгогчийн шийдвэргүйгээр үндсэн үүрэгт ажлаасаа өөр ажил гүйцэтгэж байгаад осолдох;

1.7.2. ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэнээс осолдох ;

1.7.3. ажлын байраа орхиж явсан, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан боловч технологийн горимыг ажилтан өөрөө санаатайгаар өөрчилснөөс осолдох;

1.7.4. гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулах.

1.8. Иргэд хоорондын гэрээгээр ажил гүйцэтгэх үед болон иргэний машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэх, бусад хэлбэрээр ашиглах явцад гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг гэрээ байгуулж байгаа талууд тухайн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу судлан бүртгэнэ. Хэрэв гэрээнд энэ талаар тусгагдаагүй бол ажил гүйцэтгүүлэгч тал гарсан осол, хурц хордлогыг судлан бүртгэж, хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулна.

1.9. Батлан хамгаалах, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, уул уурхайн аврах албанд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг энэ дүрмийн дагуу судлан бүртгэж, хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулна.

1.10. Тусгай зөвшөөрлийн дагуу гадаадад ажиллах хүч гаргаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар зуучлуулсан иргэн гадаадад ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осол, хурц хорлогод өртсөн тохиолдолд осолтой холбоотой нөхөн төлбөрийн асуудлыг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тухайн оронд мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Гадаадад ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осолд өртсөн иргэн нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээний дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан бол тусгай зөвшөөрлийн дагуу гадаадад ажиллах хүч гаргаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь ослыг судлан бүртгэнэ.

1.11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад эмнэлгийн задлан шинжилгээ хийлгүүлэх, мэргэжлийн байгууллагаар судалгаа, дүгнэлт гаргуулахаар хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчаас тавьсан шаардлагыг холбогдох байгууллага шуурхай барагдуулах үүрэгтэй.

Хоёр. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс, түүний ажиллах журам

2.1. Ажил олгогчоос үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус

байнгын комиссыг ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажил олгогчийн шийдвэрээр байгуулж, комиссын даргыг томилно.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас нэг, ажил олгогч болон ажилтны төлөөлөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэйгээр Засаг даргын захирамжаар байгуулсан комисс дараах нөхцөл байдалд гарсан ослыг судлан бүртгэж, акт тогтооно:

2.2.1. жижиг, дунд үйлдвэрт гарсан;
2.2.2. хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа;

2.2.3. хувиараа хөдөлмөр эрхлэх үед.

2.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын онцлог, бий болсон нөхцөлөөс хамааран энэ дүрмийн 2.2-т заасан комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

2.4. Томилолт, гэрээ, дайчилгааны дагуу өөр байгууллагад ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон цагдаагийн байгууллагын ажилтан, цэрэг, хоригдол, дадлага хийж байгаа оюутан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд түүнийг гарсан ажил олгогчид хамааруулан бүртгэх ба энэ дүрмийн 2.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд харьяалах байгууллагын төлөөллийг оролцуулна.

2.5. Энэхүү дүрмийн 2.1, 2.2, 2.10-т заасан комисс (цаашид "комисс" гэх) нь осолдогч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхийг үл харгалзан энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтаар баталсан "үйлдвэрлэлийн ослыг тогтоосон акт" (цаашид "акт" гэх)-ын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэнэ.

2.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг тогтоосон актад комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Актад үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахад хүргэсэн шалтгаан, хүчин зүйлийг тогтоож, осолдогч (осолдогч нас барсан тохиолдолд гэрч)-ийн гаргасан тайлбарыг хавсаргана.

2.7. Үйлдвэрлэлийн осол тогтоосон актыг хөдөлмөрийн, хурц хордлого тогтоосон актыг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тус тус хянан батална. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь нас хохирсон тохиолдлыг хяналтын улсын байцаагч тусгайлан судалж, дүгнэлт гаргана.

2.8. Энэ дүрмийн 1.7-д заасан ослыг судлан тогтоосон актыг баруун доод буланд "осолдогчийн буруугаас болсон" гэсэн тэмдэглэгээ хийж, ажил олгогч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж тогтоосон акт, дүгнэлтийг 4 хувь үйлдэж, осолдогч буюу түүний гэр бүлийн хүмүүст, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, орон нутгийн хөдөлмөрийн буюу хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид ажлын 3 өдөрт багтаан тус бүр 1 хувийг өгнө. Ажил олгогч болон аймаг, нийслэл, сум, дүүргийн комисс акт, дүгнэлтийн 1 хувийг архивын нэгж болгон хадгална.

2.10. Ноцтой, хор аюул, хохирол ихтэй үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд Засгийн газраас тухай бүрт нь томилсон комисс судлан бүртгэнэ.

Гурав. Комиссын эрх, үүрэг

3.1. Комисс нь дараахь эрхтэй байна:

3.1.1. үйлдвэрлэл, ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай биелчлэн танилцах;

3.1.2. үйлдвэрлэлийн ослын шинж байдлаас хамааран мэргэжилтэн, шинжээч оролцуулах, ослыг бүртгэх ажилд зөвлөгөө, тусламж авах, ослын талаар техникийн тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, дүгнэлт гаргуулах, эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэх;

3.1.3. осолдогч болон осол, хурц хордлого гарах үед байсан гэрчийн этгээд, мэргэжилтэн, удирдах ажилтнаас мэдээлэл, ярилцлага авах, холбогдох бичиг баримттай танилцах;

3.1.4. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлах явцад шаардлагатай ажлын байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах.

3.2. Комисс нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

3.2.1. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 хоногийн дотор магадлан шалгаж шийдвэрлэх;

3.2.2. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах;

3.2.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан тогтоосон акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад сэрэмжлүүлэх хийх, судалж зохион байгуулах, ажил олгогчид шаардлага, зөвлөмж хүргүүлэх.

Дөрөв. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд бүрдүүлэх баримт бичиг

4.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1. осолдогч бүрээр гаргасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт;

4.1.2. осолдогчоос авсан тайлбар, тодруулсан ярилцлагын тэмдэглэл, осолдогч нас барсан тохиолдолд гэрчийн тодорхойлолт, түүний ярилцлагын тэмдэглэл;

4.1.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байр, тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийн гэрэл болон бүдүүвч зураг, схем, дүрс бичлэг;

4.1.4. үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбоотой асуудлаар холбогдох хүмүүсээс авсан мэдээлэл, ярилцлага;

4.1.5. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын зэрэг (хүнд, хөнгөн) шалтгааны талаархи эмнэлгийн болон мэргэжлийн шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээ, туршилтын дүн;



4.1.6. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн осолдогчид өмнө нь өгсөн аюулгүй ажиллагааны зааварчилгааны бүртгэлийн хуулбар, сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт;

4.1.7. осолдогчид ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгосон тухай баримтын хуулбар;

4.1.8. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны болон осолдогчийн аюулгүй ажиллах эрх, үүргийг тодорхойлсон дүрэм, заавар, тушаал, хууль тогтоомжийн холбогдох хэсгийн хуулбар;

4.1.9. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас;

4.1.10. хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);

4.1.11. цогцост задлан шинжилгээ хийсэн тухай шүүх эмнэлгийн дүгнэлт;

4.1.12. шаардлагатай бусад баримт бичиг.

Тав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай мэдээлэх, тайлан гаргах

5.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай осолдогч өөрөө, эсхүл осол, хордлогыг анх харсан хүн ажил олгогчид тэр даруй мэдээлнэ.

5.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээллийг хүлээн авамагц ажил олгогч, комисс нь осолдогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргүүлнэ. Хүнд буюу хүний амь нас хохирсон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд орон нутгийн мэргэжлийн хяналт болон цагдаагийн байгууллагад энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтаар баталсан "үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас" болон утсаар мэдэгдэнэ.

5.3. Ажил олгогч нь комисс ирж судалгаа, шинжилгээ хийх хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авна.

5.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авч тухайн үеийн байдалд хэвээр байлгах нь бусад ажилтны эрүүл

мэндэд сөргөөр нөлөөлөх, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг алдагдуулах, улсын аюулгүй байдалд нөлөөлөхөөр байвал ажил олгогч уг байрны тухайн үеийн байдлыг дүрс бичлэг, гэрэл болон бүдүүвч зургаар бэхжүүлэн авсан байна.

5.5. Ажил олгогч болон комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээг актын хамт тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

5.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар ажил олгогч, комиссоос ирүүлсэн мэдээг хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь хагас, бүтэн жилээр энэ дүрмийн 3, 4 дүгээр хавсралтаар баталсан маягын дагуу нэгтгэж, хөдөлмөрийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 7 дугаар сарын 10 болон дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ.

5.7. Хөдөлмөрийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэсэн тайлан мэдээгээ хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлнэ.

Зургаа. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбогдсон маргааныг шийдвэрлэх

6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар гаргасан ослын актыг ажил олгогч, ажилтан зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн мэргэжлийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

6.2. Үйлдвэрлэлийн осол гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн тохиолдолд үйлдвэрлэлийн ослын актыг нөхөн тогтоохгүй.

6.3. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь комиссоос гаргасан үйлдвэрлэлийн ослын актыг хүлээн зөвшөөрөхгүй бол дүгнэлтээ тусад нь гаргаж болно.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 1 дүгээр хавсралт

Батлав.....
Хөдөлмөрийн /хөдөлмөрийн эрүүл ахуйн/ хяналтын улсын байцаагч
/гэмдэг дарна/

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫГ ТОГТООСОН АКТ

200... оны ... сарын ... өдөр үйлдвэр.

1. Аж ахуйн нэгж байгууллагын нэр

Байгууллагын хаяг /аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамжны нэр/

2. Өмчийн хэлбэр

3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн хүний овогнэр



Төрсөн он.....сар..... өдөр, нас хүйс.....

Иргэний үнэмлэхийн дугаар Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар.....

Албан тушаал

Боловсрол мэргэжил

Ажилд орсон он..... сар.....өдөр, тушаал шийдвэрийн дугаар

Нийт ажилласан хугацаа үүнээс тус байгууллагад шимтгэл төлж ажилласан хугацаа

4. Байгууллагын захиргаанаас аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилга авсан байдал

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсанон
..... сар өдөр

6. Эрүүл мэндийн үзлэгт хамгийн сүүлд орсон он сар.....өдөр

7. Оршин суугаа хаяг

8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсанонсар..... өдөр цаг
..... минут

9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан цех, тасаг, хэсэг, ажлын байрны нэр

10. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын байдал /хөнгөн, дунд, хүнд бүлэг, нас барсан

11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын хэлбэр /зур/ яс хугарах, үе мултрах, зөөлөн эд гэмтэж
бяцарсан, тасарсан, зүсэгдсэн, гадаад, дотоод гэмтэл, биологи, химийн бодисын үйлчлэл

12. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахад хүргэсэн шалтгаан, хүчин зүйл

13. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд учирсан хохирол

14. Комиссын дүгнэлт: үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг гаргахад шууд нөлөөлсөн хүчин зүйл,
шалтгаан, үйл ажиллагааны тухай тодорхой заана

15. Комиссын шийдвэр:

АКТ ТОГТООСОН КОМИССЫН

ДАРГА /...../

ГИШҮҮД /...../

..... /...../

..... /...../

..... /...../

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан
бүртгэх дүрмийн 2 дугаар хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН ТУХАЙ ЯАРАЛТАЙ МЭДЭГДЭХ ХУУДАС

1. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр
2. Цех, тасгийн нэр
3. Осол, хурц хордлогын хэлбэр: хөнгөн, дунд, хүнд бүлэг, хүн нас барсан /зурах/
4. Осол, хурц хордлогод өртсөн хүний тоо
5. Осол, хурц хордлого гарсанон сар өдөр цаг минут
6. Мэдэгдэл өгсөнон сар өдөр цаг минут
7. Осол, хурц хордлогын тухай мэдээлэл

Энэхүү мэдэгдлийг

нарт өгсөн болно.

Тайлбар: Мэдэгдлийг бичгээр, утсаар өгч болно. Мэдэгдлийг утсаар өгсөн тохиолдолд хаана, хэнд мэдэгдсэн тухайгаа энэхүү хуудсанд бичиж, осол, хурц хордлогын материалд хавсаргана. Мэдэгдэл өгсөн хүний албан тушаал

/...../

/гарын үсэг/

/нэр/

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан
бүртгэх дүрмийн 3 дугаар хавсралт

..... /аймаг, нийслэл, дүүргийн нэр/

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ОНЫ ДУГААР ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

/өссөн дүнгээр/

Салбар	Мөрийн дугаар	Эрчимхүү	Уул уурхай	Хөдөө аж ахуй	Барилга	Хөнгөн хунс	Зам, тээвэр, холбоо	Худалдаа аүйлчилгээ	Боловсрол	Эрүүл мэнд	Бусад	Нийгдүн
Ажилтны дундаж тоо	01											
Үүнээс эмэгтэй	02											
Ослын тоо	03											
Үүнээс: Бүлэг ослын тоо	04											
Осолд орсон хүний тоо	05											
үүнээс: эмэгтэй	06											
Нас барсан хүний тоо	07											
Хөнгөлийн бэрхшээлтэй болсон хүний тоо	08											
Хөдөлмөрийн чадвар түр алдсан хүний тоо	09											
Мэргэжлийн ахлаас өөр ажилд шилжсэн хүний тоо	10											
Ослын хэлбэр												
Хүний амь нас хохирсон	11											
Хүнд	12											
Хөнгөн	13											
Ослын шалтгаан												
Машин механизм, тоног төхөөрөмжийн гэмтэл, хийцрийн алдаанаас	14											
Технологийн процесс зөрчсөнөөс	15											
Тээврийн хэрэгсэлээс	16											
өргөх, зөхөх төхөөрөмжөөс	17											
Цахилгаан гүйдэлд цриулснаас	18											
Халалт, тулгарлт, хөлдөлтөөс	19											
Уналт, нуралтаас	20											
Хальцргаанаас												
Аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй сургаснаас	21											



Ажлын хувцас хамгаалах хэрэгсэлгүй ажилласнаас	22								
Онцгой ур чадвар шаардсан ажилд мэргэжлийн хүн ажиллуулаагүйгээс	23								
Химийн болон биологийн бодис алдагдсанаас	24								
Стандартын шаардлага хангаагүйгээс	25								
Бусад	26								
Нас									
18 нас хүртэл	27								
18-35 хүртэл	28								
35-аас дээш	29								
Ажилласан хугацаа									
5 жил хүртэл	30								
5-15 жил хүртэл	31								
15-аас дээш жил	32								
Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэр									
Төрийн болон төрийн өмч давамгайлсан	33								
Хувийн	34								
Төсвийн	35								
Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай	36								

Мөрийн дугаар 01, 02-ын дагуу бичигдэх ажилтны жилийн дундаж тоог орон нутгийн статистикийн албанаас гаргуулан авна. Бүлэг осолд 2-оос дээш хүн хамрагдсан ослыг тооцно.

Мөрийн дугаар 05-тай мөрийн дугаар 07, 08, 09-ийн нийлбэр, мөрийн дугаар 11, 12, 13-ын нийлбэр, мөрийн дугаар 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26-гийн нийлбэр, мөрийн дугаар 27, 28, 29-ийн нийлбэр, мөрийн дугаар 30, 31, 32-

ын нийлбэр, мөрийн дугаар 33, 34, 35, 36-гийн нийлбэр тус тус тэнцүү байна.

Тайлан мэдээ гаргасан:

Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

.....

/...../

.....он сар..... өдөр

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 4 дүгээр хавсралт

..... /аймаг, нийслэл, дүүргийн нэр/

ХУРЦ ХОРДЛОГЫН ОНЫ ДУГААР ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

/өссөн дүнгээр/

Салбар	Мөрийн дугаар	Эрчим хүч	Уул уурхай	Хөдөө аж ахуй	Барилга	Хөнгөн хүнс	Зам, тээвэр, холбоо	Худалдаа үйлчилгээ	Боловсрол	Эрүүл мэнд	Бусад	Нийт дүн
Ажилтны дундаж тоо	01											
Үүнээс эмэгтэй	02											
Хурц хордлого гарсан тоо	03											
Үүнээс: Бүлэг хордлого	04											



Хурц хордлогод өртөөн хүний тоо	05								
Үүнээс: эмэгтэй	06								
Нас барсан хүний тоо	07								
Хөгжлийн бэрхшээлтэй болсон хүний тоо	08								
Хөдөлмөрийн чадвар түр алдсан хүний тоо	09								
Мэргэжлийн ажлаас өөр ажилд шилжсэн хүний тоо	10								
Хурц хордлогын хэлбэр:									
Хөнгөн	11								
Дунд	12								
Хүнд	13								
Хүний амь үрэгдсэн	14								
Хурц хордлогын шалтгаан:									
Угаарын хий	15								
Органик уусгач	16								
Пестицид	17								
Нефтийн бүтээгдэхүүн	18								
Аммиак	19								
Хүчилт, шүлт	20								
Хүнд металлын нэгдэл	21								
Цэцэрэг идрэхт бодис	22								
Бусад химийн бодис	23								
Машин тоног	24								
Техөөрмжийн гэмтэл									
Тонг төхөөрмжийн битүүмжлэл алдагдсан	25								
Технологийн процесс зөрчсөн	26								
Аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй сургасан	27								
Ажлын хувцас хангаалах хэрэгсэлгүй ажилласан	28								
Онцгой үр чадвар шаардсан ажилд мэргэжлийн хүн ажиллуулаагүй	29								
Бусад	30								
Нас:									
18 нас хүртэл	31								
18-35 хүртэл	32								
35-аас дээш	33								
Ажилласан хугацаа:									
5 жил хүртэл	34								
5-15 жил хүртэл	35								
15-аас дээш жил	36								
Аж ахуй нэгж байгууллагын өмчийн хэлбэр:									
Төрийн болон төрийн өмн давамгайлсан	37								
Хувийн	38								
Төсвийн	39								
Гадаадын ба хамтарсан хөрөнгө оруулалттай	40								

Мөрийн дугаар 05-тай мөрийн дугаар 07, 08, 09-ийн нийлбэр, мөрийн дугаар 11, 12, 13, 14-ийн нийлбэр, мөрийн дугаар 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30-ын нийлбэр, мөрийн дугаар 31, 32, 33-ын нийлбэр, мөрийн дугаар 34, 35, 36-гийн нийлбэр, мөрийн дугаар 37, 38, 39, 40-ийн нийлбэр тус тус тэнцүү байна.

Тайлан мэдээ гаргасан:

Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

.....онсар..... өдөр

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009 оны 04 дүгээр сарын 15-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Ж.Амарсанаа, Д.Наранчимог /илтгэгч/, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортуналгагийн оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн Минжүүрийн Цэрэнбат, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Көкүшюван Батбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Баярт, тус яамны хуулийн зөвлөх Ш.Мөнхцэцэг нар оролцов.

Хуралдаанаар Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4/г, 6/г, 18/г дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн М.Цэрэнбат 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Үндсэн хуулийн цэцэг хандан гаргасан өргөдөлдөө:

"...Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт "Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг анагаах ухааны бэлгэсрөл олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн дараахь эмнэлгийн мэргэжилтэнд олгоно" хэмээгээд тус хуулийн 17.3.1-д "өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн эвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч" гэсэн заалт болон мөн зүйлийн 17.6 дахь хэсэгт "Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр

зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн;" Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ...эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үл болно"; Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;" 6 дахь хэсгийн "...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;" 18 дахь хэсгийн "...оршин суух газраа сонгох, гадаадаа явах..." гэсэн баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор бол хүн амын эрүүл мэндийг мэргэжлийн эмч буюу эмчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хамгаалуулах учиртай.

Гэтэл тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д тусгай зөвшөөрөлгүй этгээд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээр заасан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн дээрх заалтаас үзэхэд "дадлагажигч" гэсэн субъект гарч ирж байна. "Дадлагажигч" нь эмч мөн үү, өөрөөр хэлбэл эмчлэх үйл ажиллагаа явуулах, эмчийн хэмжээнд үүрэг, хариуцлага хүлээх эрх зүйн бүрэн чадамжтай субъект мөн үү хэмээх эздээтэй асуудал эндээс урган гарна" гээд дараахь байдлаар тайлбарласан байна. Үүнд:

" - Эрүүгийн хуулийн 197 дугаар зүйлд "эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлгүй этгээд эмчилгээ эрхэлсний улмаас үйлчлүүлэгчийн биед хүндэтвэр, хүнд гэмтэл учирсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх"-ээр заасан байна.

"...Хуулиудын хүрээнд цогцлуулан авч үзвэл "дадлагажигч" нь эрх зүйн тусгай чадамжтай субъект /их эмч/ бус бөгөөд зөвхөн анхны тусламж үзүүлэх субъект юм. Гэтэл энэхүү анхны тусламж үзүүлэх эрх, үүрэг бүхий субъект нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д заасны дагуу нэг ба хоёрдугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхээр заасан нь Эрүүгийн мэндийн тухай хууль нь зөвхөн Үндсэн хууль, Эрүүгийн хуулийн үзэл баримтлалыг зөрчсөн төдийгүй, уг

хуулийн дотоод зүйл заалтууд нь хоорондоо зөрчилдөг байгааг харуулж байна.

Энэхүү шинэчлэлн найруулгын гол агуулга нь гэвэл шинээр төгсөн гарч буй залуу эмч нарыг дадлага туршлагажуулах, нөгөө талаас эмч хоолдолтой байдаг хөдөө орон нутгийн иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээг хямд төсөр аргаар хангах зорилгоор баталсан болов уу. Эмч хүн гэдэг нь анагаахын сургуулийг төгссөн л бол бүхний мэдэгч, чадагч болдоггүй харин тэд ажил хөдөлмөрийн практикт өдөр тутам шинийг сурч, мэдэж, дадал туршлага суудаг юм.

Тийм ч учраас дэлхийн жишээс харахад анагаах ухааны салбарт төгсөлтийн дараахь сургалт буюу резидентурын сургалт гэсэн ойлголт байдаг. Энэ сургалтад оролцож буй эмч нь лицензтэй байдаг учраас суралцахыгхаа хажуугаар ажлаа хийгээд цалингаа авдаг жишгтэй. Гэтэл хуулийн шинэчилсэн найруулга өссөөр бол энэ хоёр жилийн хугацаанд тэднийг дадлагажигч нэрийн дор үндсэндээ хаясан буюу ямар нэгэн мэдлэг мэргэжил дээшлүүлэх сургалт зохиогдох нь байтугай Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд "иргэн хүн сурч боловсрох, ...эрхтэй" хэмээн заагдсан эрх нь өнөөдөр хаагдмал байна.

"Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгарварлан гадуурхаж үл болно", "...оршин суух газраа сонгох..."

Анагаахын сургууль суралцах хугацаандаа төрийн сангийн зардлаар суралцаж төгссөн бол өөрийн нь саналыг үл харгалзан орон нутагт томилогдож, харин сургалтын төлбөрөө хувиараа төлсөн бол хотод аль нэг өрхийн эмнэлэгт хуваарилгдах магадлалтай байдаг нь яав ч ардчилсан нийгмийн жишиг биш буй заа. Гэсэн хэдий ч бакалаврын сургалтын төлбөрөө яаж төлсөнөө үл хамааран хотод оршин суудаг төгсөгчдийг хөдөө орон нутагт хувиарласан тохиолдлууд цөөнгүй.

Үүнээс бол хамгийн наад зах нь ямар эрсдэл учирч болох вэ гэвээс гэр бүл салалт, тэдний үр хүүхэд өнчрөхийг үгүйсгэхгүй (бусад салбарын их дээд сургуулийг бодвол анагаахын оюутнууд олон жил суралцаж төгсдөг учраас энэ хугацаанд тэд ихэнх нь гэр бүлтэй болдог).

Энэ нь 1990-ээд олоос өмнөх захиргаадалтын үеийн Намын Төв Хорооны тогтоол шийдвэрээр эмч, эмнэлгийн ажилтныг нутаг заан томилон ажиллуулдаг байсныг санагдуулах болжээ.

"Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй"

Иргэд дадлагажигчид итгэл үнэмшилтэй хандаггүй. Сэжгээр өвдөж, сүжгээр эдгэрдэг хэмээн монгол түмэн ярьдаг билээ. Тэгвэл иргэн хүн лицензгүй эмчид итгэл үнэмшилтэйгээр хандаж чадах болов уу... Дадлагажигч эмч бүр өдөрт багаар бодоход 20 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ба 2007, 2008 оны байдлаар тэд давхардсан тоогоор 2.4 сая хүн амд нэг болон хоёрдугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн гэсэн албан бус тоо байдаг.

"...Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй"

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 90 дүгээр тушаалын хавсралтын 1.4-т "Дадлагажигчийн цалинг Засгийн газраас тогтоосон төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн сүлжээгээр олгох..." мөн тушаалын 2.2-т: "Дадлагажигчийн цалинг Эрүүл мэндийн сайдын

жил бүрийн төсвийн багцанд тусгана" хэмээн тус тус заасан байдаг.

Тэгвэл энэ тушаал амьдрал дээр бодитой хэрэгжиж байгаа эсэх нь бас л эргэлзээтэй. Журмын дагуу бол дадлагажигчид ТҮЗ (энэ ахлах зэргтэй сувилагчийн цалингийн зэрэглэл юм) зэрэглэлийн дагуу тэднийг цалинжуулах ёстой. Гэтэл дадлагажигч нарын цалин харилцан адилгүй байгаа нь эргэлзээ төрүүлж байна. 2008 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар 52 дадлагажигчийн цалингийн тодорхойлолт цугларснаас: 5 дадлагажигч огт цалингүй ажилласан, 18 нь тодорхой хугацаанд цалингүй, 4 нь 108000 төгрөг, 10 нь 160000 төгрөг, 15 нь 208000 төгрөгөөр тус тус цалинжсан байна.

Саяхныг хүртэл төгсөөд анх ажилд орсон цагаасаа хойш хагас жил гаруй хугацаанд огт цалин хөлс, хоол унааны зардал аваагүйгээр үл барам нийгмийн даатгалын шимтгэлийг дадлагажигч эмч хувиасаа төлж байсан тохиолдол ч бий (5 дадлагажигч эмчийн баримтыг хавсаргав). Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуульд хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж заасан байдаг. ..." гэжээ.

Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлээдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Д.Кёкүшюван Батбаяр Үндсэн хуулийн цэцэг ирүүлсэн тайлбартаа:

"1. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал... хууль дээдэл нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн гэх талаар:

2006 он хүртэл анагаах ухааны болон эм зүй, сувилахуурын боловсрол эзэмшүүлэх зөвшөөрөл бүхий сургууль төгсөж, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд ерөнхий мэргэжлийн зөвшөөрлийг эхний удаа 3 жилийн хугацаагаар олгож байхаар хуульчилжээ. Харин ерөнхий мэргэжлээр 2-оос доошгүй жил ажилласны дараа төгсөлтийн дараахь сургалтад хамрагдаж эмнэлгийн нарийн мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд тухайн мэргэжлийн зөвшөөрлийг эхний удаа 5 жилийн хугацаагаар олгохоор заасан байлаа. Энэ нь эмнэлгийн мэргэжилтэн олон тооны зөвшөөрлийг хуульд заасан хугацааны дараа дахин дахин авахыг шаардаж байсан хүнд суртлын тогтолцоо болсон байв.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмж, гадаадын бусад орны нийтлэг жишгийн дагуу тодорхой хугацаанд практик дадлага хийж байгаад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх эрхээ уагааргаажуулан авах тогтолцоонд шилжих нь зүйтэй болсон билээ.

Эмчилгээний шинэ арга, технологи нэвтэрч, хувийн эмнэлэг олноор байгуулагдаж, өвчний олон улсын ангилал шинэчлэгдсэн явдал нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг шинэ түвшинд гаргах, эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байгааг харгалзан Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр... эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг ерхийн, сум, сум дундын эмнэлэг 2-оос доошгүй жил дадлагажигчаар ажиллаж мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд олгож байхаар... мөн 2007 оны 12

дугаар сарын 21-ний өдрийн хуулиар дээр дурдсан заалтыг уян хатан болгох зорилгоор эхний жилд өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт, хоёр дахь жилдээ аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлал анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмчид ...эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож байхаар тогтоосон юм.

... Дадлагажигч нь ийнхүү эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахын тулд дор дурдсан нөхцөлийг заавал хангасан байвал зохино:

Нэгдүгээрт, анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн байх.

Хоёрдугаарт, Эрүүл мэндийн тухай хуулийн 17.3.1-д заасан эмнэлэгт 2 жил дадлагажигчаар ажилласан байх.

Гуравдугаарт, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн байх.

Дээрх шаардлага, нөхцөлийг хангасан дадлагажигч нь мэргэжлийн буюу эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах бүрэн эрхтэй.

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг буюу "Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй" гэсэн заалт нь тусгай зөвшөөрөлгүй этгээд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр заасан.

...Өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг эмчлэх үйл ажиллагаа хэмээн ойлгохоор Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заасан билээ. Дээрх заалтаас үзэхэд өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан их эмч, бага эмч эрхэлнэ. Дадлагажигч энэхүү үүргийг гүйцэтгэхгүй юм.

Харин хүний өвчин, эмгэг, гэмтлийг илрүүлэх, оношлох, магадлах, илааршуулах, сэргээн засах, сэргийлэх болон эх барихад чиглэгдсэн эмч, эмнэлгийн бусад мэргэжилтний дангаар буюу хамтран гүйцэтгэх үйл ажиллагааг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрахаар Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан билээ.

Энэхүү заалт ёсоор дадлагажигч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмчид туслах, түүнчлэн өвчтөнийг урьдчилан үзэж өвчин, эмгэгийн талаар тавьсан оношоо хянуулж, баталгаажуулан хамтран ажиллахаар заажээ.

Харин дадлагажигч нь бие дааж өвчтөний өвчнийг оношлох, эмийн жор бичих эрх эдлэхгүй болно.

2. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн "Хүнийг ...эрхэлсэн ажил, албан тушаал, ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг зөрчсөн гэх талаар:

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын дагуу нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт дадлагажигчаар ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Түүнчлэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 57 дугаар тушаалаар

баталсан дадлагажигч их эмчийн ажиллах журмын дагуу аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын захиргаа, мөн анагаах ухааны боловсрол олгох сургуулийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв дадлагажигч нарыг хуваарилж байна. Тухайлбал, 2007 онд улсын хэмжээнд нийт 400 дадлагажигчийг аймаг, нийслэлийн хэмжээний эмнэлгүүдэд байршуулж байснаас 205 дадлагажигч Улаанбаатарт хуваарилагдсан байжээ.

3. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн "...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй", "...хүүхэд төрүүлэх, асрах", "...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй", "...сурч боловсрох эрхтэй", "...оршин суух газраа сонгох, гадаадад явах" гэсэн заалтыг зөрчсөн гэх талаар:

Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14-т заасан ёсоор "хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай даалдвар үзүүсэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг албадан хөдөлмөр" гэсэн ойлголтод хамрааруулахаар хуульчилсан юм.

Дээр дурдсан тодорхойлолтоос харахад дадлагажигч хэсэг хугацаанд цалин хөлс, хоол, унааны зардал аваагүй, нийгмийн даатгалын шимтгэлийг хувиасаа төлж байсан зэрэг хөдөлмөрийн харилцаатай холбогдсон асуудал түүнийг албадан хөдөлмөрлүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт болон 17.6 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл үгүй байна" гэжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцгийн гишүүний тавьсан асуултын дагуу Монгол Улсын Эрүүл мэндийн сайд С.Ламбаа 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Үндсэн хуулийн цэцэг ирүүлсэн 1а/873 тоот албан бичигтээ:

"...Эрүүл мэндийн тухай хуульд дадлагажигч эмчийн талаар дараахь өөрчлөлт орсон. 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад анагаах ухааны боловсрол олгох сургуулийг их эмчээр төгсөгчид нь өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажиллах гэж өөрчлөн найруулсан. ...2007 оны төгсөлтөөс эхлэн төгсөгчдийг дадлагажигчаар ажиллуулж байна.

Дадлагажигч эмчийг Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын хавсралт дахь сүлжээний ТҮЭМ-З эрхлэгчээр цалинжуулж байгаа. ...сар бүр 208691 төгрөг олгож байна. 2008 онд өрхийн эмнэлгүүдийн санхүүжилтэд өөрчлөлт орсноос нийслэлийн хэмжээнд дадлагажигч эмч нарт цалинг хугацаанд нь өгөөгүй тохиолдол гарсан боловч



цалинг бүрэн нөхөж олгосон. 2009 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар Хөвсгөл аймгаас бусад эрүүл мэндийн газарт харъяалагдаж буй дадлагажигчийн цалинг бүрэн шилжүүлээд байна.

2007 оны төгсгөлийн 433 дадлагажигч эмчээс 144 нь, 2008 оны төгсгөлийн 610 дадлагажигч эмчээс 186 нь нийслэлд ажиллаж байна.

Дадлагажигч нар эмчлэх эрхийн зөвшөөрөлгүй атлаа эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй их эмчийн үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг үзүүлж байгаа талаар гомдол, санал үйлчлүүлэгчдээс ирээгүй болно.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 90 дүгээр тушаалаар батлагдсан "Дадлагажигч эмчийн ажиллаж журам"-ын 7.1-д дадлагажигч нь дадлагажуулагчийн удирдлага дор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж, эмчлэгч эмчийн хэмжээнд оношлогоо, эмчилгээний талаар шийдвэр гарган хянуулж, баталгаажуулна. 7.2-т зайцшгүй шаардлагаар бие даан ажиллах тохиолдолд бусад дадлагажуулагч эмчээс зааварчилга авч ажиллана гэсэн заалтын дагуу дадлагажигч нь үйл ажиллагаагаа явуулж байна.

Дэлхийн ихэнх улс оронд анагаах ухааны сургууль төгссөн их эмчийг тодорхой хугацаанд дадлага хийлгэж байж, эмчлэх эрхийн зөвшөөрөл өгч эмнэлэг ажил эрхэлдэг туршлага байдаг" гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад өргөдөл гаргагч нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 18/ дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн гэсэн шаардлагаасаа татгалзаж, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2/ дахь заалтын "эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхтэй" гэснийг зөрчсөн гэсэн шаардлагыг нэмсэн болохыг дурдав.

ҮНДЭСЛЭЛ:

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт зааснаар эмчлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан их эмч, бага эмч эрхлэх эрхтэй байна. Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалтад "эмчлэх" гэж өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн мэргэжлийн цоц үйл ажиллагааг ойлгохоор заажээ.

Дадлагажигч их эмч нь дээрх цоц үйл ажиллагааг бие даан явуулах эрхгүй учраас дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүйн дээр эмчийн мэргэжлийн онцлог, хүн амын эрүүл мэндийг хамгаалах төрийн үүрэг зорилттой уялдуулан анагаах ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн хүмүүст эмчлэх үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тодорхой шалгуур тавьдаг, тэдгээрийг тодорхой хугацаанд дадлагажуулдаг олон улсын жишиг байдаг. Эрүүл

мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д "Өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч" 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт "Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй", гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 2, 4, 6 дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт "өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч", мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь "Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй" гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Арчлцсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван зургадугаар зүйлийн 2-ийн "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ... эрхтэй", 4/-ийн "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй", 6/-ийн "...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй," гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэвлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД Н.ЖАНЦАН
Ж.АМАРСАНАА
Д.НАРАНЧИМЭГ
Б.ПҮРЭВНЯМ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> сэтгүүлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2